



Говьсүмбэр аймаг дахь Уул уурхайн жишиг
сургууль
Политехник коллеж

ИЛТГЭЛ

Илтгэлийн сэдэв: Мэргэжлийн болон техникийн боловсролын салбар дахь
“Үндэсний бичиг”-ийн боломжууд

Илтгэгч: Монгол хэл бичиг, уран зохиолын багш /Б.Шинэбаяр /
Уул уурхайн технологийн багш /М.Баярмаа/
Мэдээллийн технологийн багш /М.Сандагсүрэн/

Говьсүмбэр аймаг
2023 он

Агуулга

Агуулга _____	2
Оршил _____	3
Түлхүүр үг _____	3
Судалгааны үндэслэл: _____	3
Судалгааны ажлын зорилго: _____	3
Судалгааны зорилтууд: _____	4
Судалгааны арга зүй _____	4
Сэдвийн судлагдсан байдал _____	4
НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ: ҮНДЭСНИЙ БИЧГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН ТУХАЙ _____	8
1.1 "Монгол бичгийн үүсэл гарал түүх" _____	8
1.2 Монгол бичгийн хөгжил _____	10
1.3 Монгол бичгийн сан хөмрөг _____	12
ХОЁР ДУГААР БҮЛЭГ: СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ТУХАЙ _____	13
2.1 Соёлын биет бус өв гэж юу вэ? _____	13
2.2 Монгол улсад соёлын биет бус хэдэн өв бүртгэлтэй байдаг вэ? _____	14
2.3 Та хэрвээ өөрийгөө соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч гэж бодож байвал хэрхэн хаана бүртгүүлэх вэ? _____	14
2.4 Үндэсний бичиг соёлын биет бус өвд орсон байдал _____	15
ГУРАВ ДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ХЭСЭГ _____	16
3.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын төлөвлөгөөн дэх үндэсний бичгийн хөтөлбөрийн судалгаа _____	16
Судалгааны нэгдсэн дүгнэлт _____	25
Ном зүй _____	26

Зургийн гарчиг

No table of figures entries found.

График

No table of figures entries found.

Хүснэгт

No table of figures entries found.

Оршил

XIII зуунаас эхлэн монголчууд монгол бичгийг төрийн үйл хэрэгт болон шинжлэх ухааны бүтээл туурвилыг бүтээхэд хэрэглэсээр ирсэн, албан ёсны сонгодог төдийгүй дэлхийн бичиг соёлын нандин өв юм. Монгол үндэстэн оршин тогтнох соёл, сэтгэлгээний баталгаа болсон монгол бичгээ сурч эзэмших, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, өвлүүлэх, хөгжүүлэх нь Монгол хүн бүрийн төдийгүй дэлхийн бичиг соёлын өв сангийн өмнө монголчуудын хүлээж байгаа эрхэм үүрэг юм.

Өнөөгийн монгол бичгийн сургалт, хэрэглээний нөхцөл байдалд хийсэн шинжилгээний дүнгээр цаашид монгол бичгийн сургалтыг дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсролын салбарт эрчимжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, стандарт дүрэм, журмыг шинэчлэн батлах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, үүрэг оролцоог нэмэгдүүлэх, уялдуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Түлхүүр үг

- Үндэсний бичиг
- Мэргэжлийн боловсрол
- Өв соёл
- Бүтээл
- Дэвшилтэт технологи

Судалгааны үндэслэл:

Үндэсний бичиг нь төрийн бичиг болно гэдгийг албан ёсоор хуульчлан, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт үндэсний бичгийг заавал эзэмших хөтөлбөрөөр оруулж өгсөн нь тухайн салбарын суралцагчид цаашлаад монгол үндэстэн бүр үндэсний бичгийг эзэмшин суралцах хэрэгцээ шаардлага гарч ирснийг тодорхойлж байгаа юм. Мөн үүнтэй зэрэгцэн манай салбарын суралцагчид нь үндэсний өв соёлоо дээдэлсэн бүтээлч ур чадвар, өндөр мэдлэгтэй мэргэжилтэй ажилтан болоход сургалтын чанар сайн байхаас гадна оролцооны клуб, дугуйлан секцэд хамруулах, суралцагчийн хувийн авъяас, ур чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна.

Судалгааны ажлын зорилго:

Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын сургалтаар суралцагчдад үндэсний бичгээр дамжуулан монгол өв соёлыг өвлүүлэн хөгжүүлэх, түгээх, тээх, дэвшилтэт технологитой хослуулан санхүүгийн эх үүсвэр бий болгох, дэлгэрүүлэхэд судалгааны зорилго оршино.

Судалгааны зорилтууд:

- Үндэсний бичгийн үүсэл хөгжлийн тухай онол арга зүйг судлах
- Соёлын биет бус өвд багтсан үндэсний бичгийн тухай судлах
- Мэргэжлийн болон техникийн боловсрол дахь үндэсний бичгийн агуулгын судалгааг гаргах
- Суралцагчдад үндэсний бичгээр дамжуулан монгол өв соёлыг өвлүүлэн тээх хөгжүүлэх боломжийг судлах
- Мэргэжлийн болон техникийн боловсролын онцлогтой уялдуулан үндэсний бичгийн бүтээл, хөрөнгө оруулалт, санхүүгийг боломжуудыг нээн илрүүлэх
- Үндэсний бичгийн төрлүүдийг дэвшилтэт технологийг ашиглан фонт зохиох, аппликейнаар дамжуулан орлогын эх үүсвэр бий болгох
- Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэх, хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох

Судалгааны арга зүй

- Мэдээлэл түүвэрлэх, эх сурвалжийн анализын аргыг сэдвийн судлагдсан байдлыг тогтоож онолын хэсгийг боловсруулахад
- Ярилцлагын аргыг судалгааны нэгдсэн үзүүлэлтэд үнэлэлт, дүгнэлт өгөхөд
- Статистик боловсруулалтын аргыг цуглуулсан мэдээллийг нэгтгэн дүгнэх, харьцуулалт хийж, боловсруулахад ашиглав.
- Туршилт судалгааны аргаар бодит үр дүн, суралцагчдын ахиц дэвшил, санхүүгийн боломж эх үүсвэр бий болгож байгааг
- Аналитик судалгааны аргаар сургуулиудын хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ хийхэд

Сэдвийн судлагдсан байдал

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Соёл, урлагийн газраас улс орон даяар “Үндэсний бичиг үсгийн баяр-2018” цуврал арга хэмжээний үеэр “Үндэсний бичиг үсэг-Өв, соёл, хэрэглээ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал болж байсан. Тус эрдэм шинжилгээний бага хуралд БСШУСЯ, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Соёл урлагийн газар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны эрдэмтэн, мэргэд, доктор, профессорууд оролцсон байдаг. Эрдэм шинжилгээний бага хурлаар эртний бичиг үсэг, монгол хэл бичгийг дагнан судалдаг эрдэмтэн мэргэдийн төлөөлөл болсон хүмүүс 10 гаруй илтгэл тавьж, хэлэлцүүлжээ. Тухайлбал,

1. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн академич, доктор Л.Болд “Чингис хааны үеийн чулууны бичээсийн үг хэллэгт хийсэн судалгаа”

2. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн академич, доктор Д.Төмөртоогоо “Монгол дөрвөлжин бичиг, түүний дурсгал”
3. “Монгол бичгийн уламжлал, шинэчлэл”,
4. “Соёмбо үсгийн содон бичлэг”,
5. “Эртний монгол хэлний дурсгал-Хүйс толгойн бичээс”,
6. “Тод үсгийн судалгааны байдал, бүтээл туурвил”,
7. “Бийрээр урласан бэхийн мөр”,
8. “Монгол таталган бичлэгийн тухай” гээд олон сонирхолтой илтгэлийг тавьжээ.

Онлайн цуврэл илтгэл – Монгол Брахми бичиг

Илтгэлийн хураангуй:

Монголчууд аль эртнээс хоорондоо харьцаа холбоогүй рүни, брахми, кидан, уйгаржин зэрэг дөрвөн зүйлийн монгол үсэг бичгийг хэрэглэж байжээ. “Бугатын хөшөөний бичээс” хийгээд “Хүйс толгойн бичээс” зэрэг нь манай эриний VI болон VII зууны үеэс эхлэн монголчууд өөрийн үндэсний “өвөг монгол хэл”-тэй байснаар барахгүй тус үг хэлээ тэмдэглэсэн “монгол брахми бичиг”- тэй байсныг харуулж байгаа юм. Энэ монгол брахми үсэг бичиг нь дээрээс доош, баруунаас зүүнш босоогоор бичдэг авиа хийгээд үеийн бүтэцтэй хамгийн эртний нүүдэлчин ардын хэрэглэж байсан босоо үсэг бичиг болно. Брахми бичиг нь 2 дан эгшиг, 3 харьяат эгшиг, 24 гийгүүлэгчтэй 31 үсэг тэмдгээр бичигдэнэ.

Мөн төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгааг Үндэсний статистикийн хорооноос анх удаа 2021 онд явуулжээ. 2015 онд Монгол хэлний тухай хуулийг УИХ-аас батлахдаа 7.2-т энэ хуулийн 11.1.2-т заасан “Үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулахаар заасан бөгөөд уг заалт 2025 оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхлэх тухай хуульчилсан. Энэ хүрээнд ҮСХ Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн захиалгаар уг судалгааг зохион байгуулжээ. Судалгаанд төрийн 149.1 мянган албан хаагчийг хамруулж, Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, сургалтад хамрагдах хэрэгцээ байгаа эсэх, сургалтыг ямар хэлбэрээр авч болох талаарх дараагийн шатны үйл ажиллагааг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг цуглуулсан байна. Говь-Алтай аймаг 2021 оны дөрөвдүгээр сараас орон нутгийн албан хэргийг Үндэсний бичигтэй хослуулан хэрэглэж эхэлжээ. 2025 оны нэгдүгээр сараас хэрэгжих төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагад албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд Та бэлэн үү?” гэсэн асуултад төрийн албан хаагчдын 53.6 хувь нь “Тийм” гэсэн бол үлдсэн 46.4 хувь нь “Үгүй” гэж хариулжээ. Баян-Өлгий аймгийн судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 62.5 хувь нь албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан

хэрэглэхэд бэлэн биш буюу “Үгүй” гэж хариулсан нь улсын дундаж болон бусад аймагтай харьцуулахад төрийн албан хаагчдын үндэсний бичгийн талаарх ойлголт, мэдлэг бага байгааг илтгэж байна. Говь-Алтай аймгийн төрийн албан хаагчдын 74.7 хувь нь албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн гэж хариулсан нь нь улсын дундаж болон бусад аймагтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм. Говь-Алтай аймгийн удирдлагын шийдвэрээр тус аймаг нь 2021 оны 4 дүгээр сараас эхлэн орон нутгийн албан хэргийг Үндэсний бичигтэй хослуулан хэрэглэж байгаа бөгөөд аймгийн төрийн албан хаагчдыг Үндэсний бичгийн сургалтад хамруулж эхэлсэн байна. Тус аймгийн төрийн албан хаагчид эхний шатны сургалтад хамрагдсан хэдий ч судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 74.7 хувь нь албан бичиг хэргээ Үндэсний бичигтэй хослуулан хэрэглэхэд бэлэн гэж хариулснаас харахад сургалтын ач холбогдол нэлээд их байгааг илтгэж байна.




График 1: Үндэсний бичгийн мэдлэгийн түвшингийн судалгаа насны ангиллаар

Төрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтын хэрэгцээ, шаардлага байгаа эсэх асуултад судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 85 хувь нь “Тийм” гэсэн бол үлдсэн 15 хувь нь сургалтын хэрэгцээ, шаардлага байхгүй гэж үзсэн байна.

Энэ үзүүлэлтийг аймгаар харвал

- Говь-Алтай аймгийн төрийн албан хаагчдын 93 хувь
- Баянхонгор аймгийн 91.4 хувь
- Булган аймгийн 91.1 хувь
- Завхан аймгийн 90.9 хувь нь сургалтын хэрэгцээ, шаардлага байна гэсэн бол
- Баян-Өлгий аймгийн 25.6 хувь
- Нийслэлийн төрийн албан хаагчдын 18.2 хувь
- Дархан-Уул аймгийн 16.7 хувь
- Дорнод аймгийн 15.6 хувь

- Орхон аймгийн төрийн албан хаагчдын 15.5 хувь нь сургалтын хэрэгцээ, шаардлага байхгүй гэсэн байна.

Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хүсэлтэй байгаа төрийн албан хаагчдын хувьд ямар төрлийн сургалтад хамрагдах хүсэлтэй байна гэсэн асуултад 56.1 хувь нь танхимын сургалт, 43.1 хувь нь цахим сургалт, 0.8 хувь нь бусад хэлбэрийн сургалтад хамрагдах хүсэлтэй гэжээ. Мөн хосолмол хэлбэрээр сургалтад хамрагдах хүсэлтэй иргэд судалгаанд хамрагдагчдын 7.3 хувийг эзэлсэн байна. Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварт онцгой анхаарал хандуулах нь зүйтэй гэж дүгнэжээ

Судалгааны дүнгээр судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 5.2 хувь нь өөрийнхөө үндэсний бичгийн түвшинг “Маш сайн” гэж үнэлсэн бол 13.4 хувь нь сайн, 28.7 хувь нь дунд зэрэг, 25.4 хувь нь бага зэрэг, 27.2 хувь нь үндэсний бичгийн үсэг, тоо мэдэхгүй, ялгахгүй, уншихгүй, бичихгүй буюу ямар нэгэн мэдлэг огт байхгүй гэж хариулжээ.

НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ: ҮНДЭСНИЙ БИЧГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН ТУХАЙ

1.1 "Монгол бичгийн үүсэл гарал түүх"

Чингис хаан 1206 онд Их Монгол улсыг байгуулан Монгол угсаатаныг дахин сэргээн мандуулж, эдүгээ хүртэл оршин байх үндсийг бататгасан билээ. Тулгар улсын алив хэргийг явуулахын тулд Уйгур үсгээс Тататунга нэрт бичгийн хүн Монгол үсгийг зохиожээ гэж зарим эрдэмтэд үздэг. Үүнд төрийн албан ёсны бичиг болгосон хэмээх санааг XVII зууны Лу. Алтан товчид дурдсаныг эш болгодог. Харин үүнийг "мөхсөн" Уйгураас бичиг үсэг авсан байх үндэсгүй Согдоос Уйгуртай зэрэгцэн аль эрт бичиг үсэгтэй болсон байх боломжтой гэж олон эрдэмтэн өөрөөр тайлбарладаг. Уламжилж ирсэн бичгийг Чингис хаан нэгдсэн төрийн албан ёсны үсгээр зарлигдсаныг тэр цагаас үүссэн мэтээр тайлах нь буруу гэж эдгээр судлаачид үздэг. Үүний нэг баримт нь Чингис хааныг нас барахаас өмнө ба дараа бичигдсэн "Чингисийн чулууны бичиг", Монголын нууц товчоонд бичиг үсгийн нилээд урт хугацааны боловсорсон төлөв илэрхий ажиглагдаж байдаг ажээ. Гэвч Чингис хаан Найман аймгийг нэгтгэсний дараа олзлогдсон бичээч Тата-Тунга нь эртний Иран дахь Согд бичгээс үүссэн хуучин Уйгур бичигээр үндэс болгож зохиосон гэдэг үзлийг баримтлах явдал бас байсаар байдаг. Тататунга төрийн албан бичгийг улам хөгжүүлэх үйлсийг эрхэлсэн байж болох юм.

Монголчууд эхэндээ "Уйгаржин бичиг" гэж нэрлэдэг байсан гэдэг. Мөн онцлог шинжүүд болоод бусад монгол түүхэн бичгүүдээс ялгах зориулалтаар Босоо бичиг, Хуучин Монгол бичиг, Худам Монгол бичиг гэж олон янзаар нэрлэж байжээ.

Монгол хэлээр бичигдсэн монгол бичгийн анхны дурсгал нь 13-р зуунд урласан Чингисийн чулууны бичиг юм. Уг бичиг нь зөвхөн босоо чиглэлд бичдэгээрээ онцлог. Мөн үгийн эхэн дунд адагт буй үсгийн хэлбэр нь өөр өөр хэлбэртэй. Монгол бичиг нь Баруун Монголын ойрад аялгуунд тулгуурласан тод бичиг, буриад аялгуунд ойртуулсан вагиндрагийн үсэг гэх мэт хэд хэдэн хувилбартай. Мөн Аюуш Гүүшийн зохиосон галиг үсэг болох Али-Гали нь уйгаржин үсгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан бөгөөд уг үсгээр монгол хэлнээс гадна төвөд, самгард, хятад хэлний үгийг тэмдэглэх өргөн боломж нээгдсэн.

Монгол бичгийн үүсэл гаралтай холбоо бүхий хоёр зүйлийн домог өдгөө бидэнд мэдэгдэж байна. Нэг нь XVIII зууны үед Рабжамба Данзандагвын зохиосон "Зүрхэн тольтын тайлбар огторгуйн маани" хэмээх хэлзүйн бичигт "Тэр цагт Зая Бандид (Зая Бандид Гунгаажалцан) Монгол улсад аль үсгээр туслах болох хэмээн шөнө түгдэм барьж эрт манагар бэлэглэхүйд нэгэн эхнэр хүн мөрөн дээрээ хэдрэг модыг тавьж ирээд мөргөвөөс, тэрхүү бэлгээр Монгол улсын үсгийг хэдэргэний

дүрсээр нь эр, эм, эрс гурваар, чанга хийгээд хөндий ба саармаг гурваар зохиосон болвой" гэсэн домог юм. Энд өгүүлсэнчлэн Саж Бандид Гунгаажалцан (1182-1251) монгол үсгийг анх зохиосон бус харин тэрбээр 1243 онд 61 насан дээрээ монгол бичгийн хэлний авиа зүйн бүтээл буюу анхны зүрхэн тольт зохиосон болох нь нэгэнт тодорхой болжээ. Хоёр дахь нь "Юан улсын судар"-ын 124-р ботод байгаа Уйгар түшмэл Тататунгаатай холбогдсон домог юм. Тэнд өгүүлэхдээ: "Чингис өрнөш дайлж, Найман улс эвдрэхүйд Тататунга тамгыг өвөртлөн дайжаад баригдав. Чингис хаан ухавчлах асууруун: - Даяны иргэд, нутаг цөм миний болсон бөгөөтөл чи бээр тамга өвөртлөн хааш очмүй хэмээхэд тэрбээр: "Түшмэлийн тушаал болмой. Үхтэл сахиж, угийн эзэнд өгсү хэмээмүй. Ямар аймшиггүй өөрийг сэтгэх аж." хэмээжүхэй, Хаан зарлиг болж "Шудрага элбэрэлт хүн ажгуу" хэмээгээд тамгыг юунд хэрэглэхийг асууваас, "Аму цалинг оруулах, гаргах, эрдэмтнийг өргөмжлөх аливаа үйлд итгэмж болгомуй." хэмээсэнд хаан таалж шадар болгожихуй. Түүнээс хойш засаг зарлиг тамга хэрэглэн үүсгэж мөн түүгээр захируулав. Хаан "Чи тус улсын бичгийг нэвтэрхий мэдмүй." гэхэд тэрбээр сурсанаа өчсөн нь зарилagt нийлэлцсэн тул даруй хөвгүүд, дүү нарт уйгар үсгээр улсын хилийг тэмдэглэхэд сургагтун хэмээн захив." гэсэн байдаг. Чингис хаан Найманыг 1204 эзэлж авсан нь үнэн. Харин энэ үед монголчууд анх бичиг үсэгтэй болсон хэрэг огт биш бөгөөд алдарт зохиолч эрдэмтэн Б.Я.Владимирцовын бичсэнчлэн Чингис хаан өөрийн эзэнт улсын хэрэгцээнд ихээхэн боловсорсон бэлэн утга зохиолын хэлийг авч ашигласан ажээ. Өөрөөр хэлбэл монголын зарим аймагт хэрэглэж байсан бичгийг Чингис хаан эзэнт улсынхаа хүрээнд хэрэглэжээ. Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтэн Г.Д.Санжеев энэ тухай "Ямар ч гэсэн 1204 онд Чингис хаан Найманыг бут цохиж, Найманы Таян хааны тамгыг барьж байсан нэгэн уйгарыг олзолж, түүний тусламжаар төрийнхөө бичиг хэрэгт уйгар үсэг дээр үндэслэсэн монгол бичиг үсгийг хэрэглэсэн бололтой гэсэн нэгэн домог байдаг. Гэвч хэргийн гол Чингис хаан төрийнхөө бичиг хэргийг Согдоор дамжиж, Арамейгаас ирсэн шинэ үсгээр явуулах тухай тушаал гаргасанд бус, харин Чингис хааны үед монголчууд нэгэнт ямар нэгэн хэмжээгээр бэлхэн болоод байсан утга зохиолын хэлийг хэрэглэж эхэлсэнд оршино." гэжээ. Монголчууд XIII зуунаас хол эрт уйгаржин бичгийн хэлтэй байсны гол баримт бол уйгаржин бичгийг хэл XIII, XIV зууны монголын аман аялгуунаас ихээхэн ялгаатай байгаа явдал юм. XIII-XIV зууны үеийн монгол аялгууг бусад хэлэнд галиглан тэмдэглэсэн ном зохиол, толь бичиг тэргүүтнээс бид тухайн үеийн монгол үгсийн дуудлагыг олж мэдэж болдог билээ. Хэл гэдэг тийм цөөн жилийн дотор амархан-өөрчлөгддөг зүйл биш бөгөөд алгуур аажим хувьсдаг учраас бичгийн хэл нь аман аялгуунаасаа ихээхэн зөрөөтэй байна гэдэг бол тэрхүү бичгийн хэл, бичиг үсэг олон жилийн өмнө үүссэн гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Монголчууд XIII зууны үед боловсорсон утга зохиолын хэлтэй, бичиг хэрэг хөтлөх тогтсон уламжлалтай байсны нэг нотолгоо бол 1225 онд бичсэн Чингисийн чулууны бичиг юм. Уг бичээст мөр тэтгэж бичих ёс тун нарийн харагдаж байдаг.

Монголчуудын дунд "Уйгаржин монгол бичиг", "монгол бичиг", "Худам монгол үсэг" анх хэдийд, хаанаас авсан тухай сүүлийн үед эрдэмтэн, судлаач нар өөр өөрийн бодол саналыг дурдсан байна. Манай эрдэмтэн Ц.Шагдарсүрэн "Монголчууд XIII зуунд согд үсгийг уйгараас дам авч хэрэглэсэнгүй, харин VI-VII зууны үед Монгол, Уйгар одоогийн Тажикийн дээд өвөг Согд нараас нэгэн зэрэг бичиг үсэг авсан байж болох баримт гарч байна." хэмээн бичсэн буй. Мөн Өвөр Монголын эрдэмтэн Данзан "Монгол бичгийн үүслийн цагийн асуудал" хэмээх шинжилгээний томоохон өгүүлэлдээ "Эртний монголын хэл аялгууны байдал, эртний монгол орон дахь бичгийн соёлын байдал, эртний монгол орны аймаг угсаатны соёлын харилцааны байдал ба хуучин монгол бичиг дэх хэлний болон үсэг зүйн онцлог зэргийг ерөнхийд нь шинжилж үзвэл, монголчууд XIII зуунаас хол эрт согд гаралтай уйгар үегийг авч хэрэглэсэн бөгөөд бодитой цагийн талаар 805-840 оны хооронд буюу эсхүл 971-1125 оны хооронд буюу гэх хоёр цаг үед хэрэглэж эхэлсэн боломж нь өөр үеэс илүү байна." гээд түүнийгээ олон баримтаар батлахыг хичээсэн байна.

1.2 Монгол бичгийн хөгжил

Монгол үгийг анхлан боловсруулахдаа уйгар үсгийн арван дөрвөн толгой нь монгол хэлний үг бүтээх авиалбарын тооноос арай цөөн тул хошоод, гурваад дүрсийг нийлүүлэн зарим үсгээ тэмдэглэсэн билээ. Тухайлбал ө, ү гэхэд аалеф, вав, йод гурвыг холбож бүтээжээ. Олон зуун жил монгол бичгээ сурч, сургаж ирэх явцад тэрхүү дүрс, зурлага бүрт тусгай нэр цол өгсөн нь заах аргын өвөрмөц нэгэн зүйл юм. Титэм, шүд, ацаг, өргөс, шилбэ, завж, гэдэс, сүүл, орхиц, нум, нуруу, эвэр, гээг, зартиг гэх мэтээр монгол бичгийнхээ зурлага, дүрс бүрийг ялган нэрлэсэн нь бичих хэрэглэлгүй нөхцөлд амаар хэлж өгөх боломжийг бүрдүүлэжээ. Жишээ нь монгол гэсэн цэгтэй, дор нь гэдэс, төгсгөлд нь дэвсгэр "л" буюу эвэр гэх болно.

Нэн эрт цагт үсэг бичгээ боловсруулсан мэргэд маань голчлон нутгийн аялгууг нэн сайтар анхаарч, нутаг нутагт нэгтгэн хэлдэг авиаг адил дүрсээр тэмдэглэсэн байдаг. Жишээ нь эрт одоогийн зарим аялгуунд үгийн эхэнд "ж" нь "я" болдог ү зэгдлийг нарийн ажиглаж, адил дүрсээр тэмдэглэсэн тул засаг, ясаг, жасаг гэж дуудах б ү рэн боллоцоотой байдаг. Үе үеийн олон мэргэд монгол бичгийг засаж өөрчлөлгүй явж ирсний гол шалтгаан нь бол Төв Азийн өргөн уудам нутагт тархан суусан олон нутгийн аялгуутай монгол туургатныхаа алинд ч бэрхшээл түвэггүй ойлгогдох нарийн увдистай бичиг болохыг мэдэрснийх буй заа. Өөрөөр хэлбол монгол бичгийн авиан зүйн тогтолцоонд монгол хэлний нутгийн олон аялгуутай онцлогийг бахдууштай сайхан тусгаж чадсанд л хамаг учир байгаа билээ.

Монгол үсгийн бас нэгэн онцлогийг Ш.Лувсанвандан багш тайлахдаа: "хуучин монгол үсгийн нэг онцлог нь нэг үсэг үгийн эхэн, дунд, адагт янз бүрээр хувирдаг оршино. Ингэж нэг үсэг янз бүрээр хувирах нь эртний согд, уйгар үсэгт ч байсан юм. Нэг үсгийн янз бүрийн хэлбэртэй болсон нь үсгээр үг тэмдэглэхдээ уг үсгүүдийг бие биеэс нь салангид биш, залгаж бичихтэй холбогдон гарч ирсэн байна. Үг хэлэхэд хүний амнаас цувран гарсан авиа бие биендээ нөлөөлж, мөн нэг авиа үгийн эхэн, дунд, адагт янз бүрээр хувилдгийн адил үсгийг цувруулан залгаж бичихэд мөн нэг үсгийн хэлбэр зэрэглээ үсгийн бичлэгээс болж янз бүрийн хэлбэртэй болох нь зүйн хэрэг. Нэг авиа нөгөө зэрэглээ авианыхаа нөлөөгөөр хувирдаг бол мөнхүү авиаг тэмдэглэсэн үсгийн хувилбарт зохих тусалаа олж болох юм. Энэ учраас бид нэг авиаг тэмдэглэсэн үсгийн янз бүрийн хувилбарыг мөн нэг фонемын янз бүрийн хувилбартай харьцуулж үзэх бүрэн үндэстэй юм." гэсэн билээ.

Монгол бичиг он жилийн уртыг туулан боловсорч ирэхдээ эрт цагийн үгийн бүтцийг өчүүхэн ч алдагдуулалгүйгээр авчирсан нь чухамдаа монгол хэлний хөгжил хувьсал бүхнийг ташаагүй үнэн тэмдэглэсэн түүхэн сурвалж бичиг мэт ажээ. Орчин цагийн монгол хэлний дуудлагаас өөрөөр бичиж байгаа үг бүрийн цаана эх хэлний маань түүхэн хувьсал үгийн гарлын учир шалтгаан, үндэсний хэл сэтгэхүйн маань бүхэл бүтэн түүх байгаа гэдгийг онцлон дурдах нь зүйтэй болов уу. Учир нь монгол бичгээ сурч судлахыг хичээх болсон өнөө үед зарим шантарган гэнэн хүн монгол бичгийг одоогийн аялгуунд тохируулан өөрчилж болдоггүй юм уу? гэж хэлэх нь хааяа тохиолдох юм. Энэ бол туйлын аминчхан үзлийн илрэл мэт бодогдож мэдэх үг ээ.

Монгол бичгээр бичдэг ёсыг зөрчиж, хэлэх аялгаа баримтлан бичнэ гэдэг эх хэлнийхээ эд эсийг зэмдэглэн тайрч хаяна гэсэн үг бөгөөд түүгээр хойч үеийнхнийхээ өмнө уучилшгүй нүгэлтэн болж мэднэ. Учир нь монгол хэл, монгол бичиг гэгч гагц өнөөгийн бидний өмч биш. Өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн түм буман монголчуудын өмч учраас нэгэн үеийн бид дур мэдэн бичиг үсгээ өөрчилж засамжлан, хойч үеийнхээ эх хэл сэтгэхүйнх нь түүхнээс холтгох эрхгүй. Монгол бичиг бол монгол хэлний үгийн түүх гарлыг нягтлан тольдох толь бичиг юм. Наад захын үгээр жишээлэхэд хутга, хядах, чарга чирэх, гэх мэт үгийг монгол бичгээр хидуга, хидуху, чирга, чирхү гэж бичнэ. Эхний хоёр үгийн язгуур нь хиду-бөгөөд хядаж, хяргадаг юмын нэрийг хутга гэдэг болох нь илт харагдана. Нөгөө хоёр үгийн язгуур чир-бөгөөд чирч явдаг юмыг чарга гэдэг болох нь тодорхой байна.

Үсэг зүйн хувьд авч үзвэл, XVI - XVII зууны үе хүртэлх бичгийн хэв маяг, үсгийн зурлага уугуул согд, уйгар үсэгтэй их төстэй байсан бөгөөд тийм ч учраас энэ үеийн монгол бичгийг уйгаржин монгол бичиг гэж нэрлэх нь бий. XVI -XVII зуунаас

хойш, өдгөөгийн монгол бичиг үсгийн хэв маягийг олж, үсгийн зурлага, нэмэлт тэмдэг сэлт нь тогтворжин боловсорч, харь хэлний үгийг тэмдэглэх галиг үсгийн бүхэл бүтэн тогтолцоотой болж, зөв бичих дүрэм ч жигдрэн цэгцэрсэн байна. ХҮI - ХҮII зууны үед монголчуудын ном бичгийн үйлс нэн өрнөж, ном барлах, орчуулах туурвах үйл мандан дэлгэрч, сонгодог бичгийн хэл бүрэлдэн тогтжээ. Монгол бичгийн зөв бичих дүрэм жигдрэн цэгцрэхэд XIII зуунаас эхлэн удаа дараа туурвиж ирсэн олон арван хэлзүйн бичиг, олон зүйлийн толь бичиг нэн чухал байв. Эдгээр "Зүрхэн тольт" хэмээх хэлзүйн бүтээл цагаан толгой, үсгийн дүрмийг хамарсан төдийгүй хэл шинжлэл буюу дуун ухааны олон талыг багтааж байжээ. Нэгэн жишээ татахад XIII зууны эцэс, XIV зууны эхэн үед бүтээн туурвиж байсан. Чойжи-Одсэр, монгол бичгийн авиазүй, хэлзүйн онцлогийг сайн тусгаж, үгийн эцэст үе битүүлэн орж чадах гийгүүлэгч үсгийг бүртгэн тогтоож 11 дэвсгэр үсэг гэж нэрлэжээ. Эртний монгол хэлний 11 дэвсгэр гийгүүлэгчээс 9 нь орчин цагийн монгол хэлэнд нэгэн адил дэвсгэрлэн орж байгаагаас үзэхэд тэр эрт цагт монгол хэлний гийгүүлэгч авиалбарын байрлалын чухал хуулийг нээсэн ажээ. XIII зуунаас эхлэн Саж Бандид Гунгаажалцан, Чойжи-Одсэр, Рабжамба Дагзандагва, Алшаа Дандар Лхаарамба, О.Жамьян, С.Шагж тэргүүтэн олон мэргэд, олон арван цагаан толгой, "Зүрхэн тольт" хэмээх хэлзүйн дүрмийг боловсруулсаар ирсэн билээ. XX зууны эхэн үед С.Шагж багшийн "Үсгийн дүрмийн толь" гарч, өдгөө хүртэл Өвөр Монгол, Буриад бүгд л энэ толийг зөв бичих зүйн хувьд мөрдлөг болгож байгаа юм.

1.3 Монгол бичгийн сан хөмрөг

Монгол туургатан олон зууны турш үндэснийхээ бичгээр оюуны соёлын хосгүй арвин өв сан бүтээжээ. Цаг цагийн гамшиг, үе үеийн үрэгдлийг тэсч өнгөрөөсөн нь л бидэнд хүрч иржээ гэж бодоход өдгөө Монгол оронд болон дэлхийн олон орны номын санд хадгалагдаж байгаа монгол номыг мэдсэн дуулсны хэрээр хэмжээлэн санахад өөрийн эрхгүй бахдан бишрэх сэтгэл төрөх ажээ. Зөвхөн улсын нийтийн номын санд монгол бичгээр туурвисан 20000 орчим судар шастир хадгалагдаж байна. ОХУ, Монгол, АНУ, Англи, Япон, Герман, Швед, Польш, Унгар, Франц зэрэг дэлхийн олон орны номын санд монгол бичгээр туурвисан судар шастир, мөн үлэмж тоотой байгаа бөгөөд зарим орны эрдэмтэн өөрийн оронд байгаа монгол номын гарчгийг хэвлүүлсэн нь зөвхөн тусгай ном, том боть болсон байх юм.

Монгол туургатны дотроос ухаан билгээрээ тодрон гарсан олон мэргэд зүйл зүйлийн ухааны нэн арвин шастир судар туурвисан байхаас гадна эртний дорно дахины соёлт орнуудын шилдэг зохиолын орчуулгын баялаг сан хөмрөг буй болгожээ. Ганцхан жишээ дурдахад монголын их хаадын намтар, хатад, хөвгүүд, гавъяатан сайд, түшмэдийн шастир болон Юань улсын үеийн монголын эдийн засаг, соёлын түүхийг өргөн хамарч бичсэн "Юань улсын судар" хэмээх 210 дэвтэр номыг монголын нэрт бичгийн хүн, хятадач Дандаа (чухам нэр нь Дэмжигдорж)

1917-1928 оны хооронд орчуулсан нь гар бичмэлээр улсын нийтийн номийн санд хадгалагдаж байна. Мөн энэхүү "Юань улсын судар"-ын 14 дүгээр дэвтэр манж хураангуйг орчуулсан нь бас байх юм. Ганжуур, Данжуур тэргүүтэй өдий төдий судар шастирыг төвд хэлнээс орчуулсныг хэн бүхэн мэдэж байгаа. Монгол бичгээр байгаа орчуулгын сан хөмрөгт 1921-1945 он хүртэл өрнө дахины хэлнээс орчуулсан бас нэлээд арвин ном зохиол бий билээ. Монгол бичгээр бидэнд уламжлагдан ирсэн судар, шастир, намтар түүх, илтгэл шасдир, данс хараа, алба албан бичиг тэргүүтэн нь монгол туургатны туулж ирсэн зам мөр, туурвиж бүтээсэн оюун ухаан, мандаж буурсан түүхэн үнэн, шүтэж баримталсан зан үйлийг танин мэдэх гол түлхүүр бөгөөд сонгодог бичгийн найруулгын ур маяг, эх хэлнийхээ яруу сайхан, арвин баялаг үгийн санг гагцхүү монголын бичгийнхээ сан хөмрөгөөс л сурч мэдэх учиртай.

Монгол бичиг нь монгол туургатны тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг, олон аялгуутныг соёлоор холбох гүүр билээ. Өөрчлөн байгуулалтын сайн цагийн урин улиралд найман настнаас наян настан буурал, жирийн ажилтнаас төрийн сайд хүртэл хэлмэгдсэн соёлоо сэргээж, монгол бичгээ сурч мэдэхийг хичээн чармайж байгаа нь нэн сайшаалтай бөгөөд монгол бичгээ улсынхаа албан ёсны бичиг болгох нь түүхэн зайлшгүй шаардлага болон тавигдлаа. Иймээс бид эх орон, эх хэл хоёроо эрхэмлэн дээдэлж, монгол түмний ертөнцийн оюуны санд оруулсан хандив болох монгол бичгээ дээдлэн суралцах хэрэгтэй.

ХОЁР ДУГААР БҮЛЭГ: СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ТУХАЙ

2.1 Соёлын биет бус өв гэж юу вэ?

“Соёлын биет бус өв” гэдэг нь тухайн ард түмэн, үндэстний оюун санаагаар бүтэж, уламжлагдан ирсэн түүхэн тодорхой орон зайг төлөөлж чадах эх хэл, ардын мэдлэг, амьдрах арга ухаан, байгаль ертөнцийн тухай мэдлэг, хөдөлмөрийн зан үйл, наадам наргиа, ёс заншил, дуу хөгжим, уламжлалт гар урлал, түүний ур хийц, технологи зэрэг соёлын орон зайг хэлнэ.

Биет бус өвд Монголын ард түмний оюун санаагаар бүтсэн эх хэл, ардын зан заншил, мэдлэг ухаан, дуу хөгжим, наадам, ардын арга ухаан, уламжлалт технологи зэрэг соёлын өвийн олон төрөл багтдаг.

Монгол улс Соёлын биет бус өвийг анхлан Утга соёлын өв, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг Өвлөн тээгч хэмээн нэрлэж байсан ба 2010 онд Монгол улсын Төрийн хэлний зөвлөлөөс Соёлын биет бус өв, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч гэж нэрлэх нь зүйтэй гэсэн чиглэлийн дагуу одоогийн нэршилийг хэрэглэж байна.

Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч гэж хэн бэ?

“Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч” гэж тухайн өвийг мэдлэг ухаан, ур чадвар, арга барилын хувьд язгуур шинж чанараар нь маш сайн, өндөр түвшинд өвлөн уламжилж, эзэмшсэн, мэдлэг бүхий хувь хүн, ах дүү, төрөл садан бүхий ард иргэдийг хэлнэ.

2.2 Монгол улсад соёлын биет бус хэдэн өв бүртгэлтэй байдаг вэ?

Монгол улс нь Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага болох ЮНЕСКО-гийн 2003 онд баталсан “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц”-ийн Соёлын биет бус өвийг олон улсын хэмжээнд хамгаалах зарчмын дагуу Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн бүртгэл, Яаралтай хамгаалалтад авах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэл гэсэн 2 төрлийн бүртгэлийг хийж байна.

2013 оны байдлаар Монгол улсын биет бус соёлын өвийн төлөөллийн Үндэсний бүртгэлд 77 өв, Монгол улсын Яаралтай хамгаалах шаарлагатай биет бус өвийн үндэсний бүртгэлд 16 өвийг тус тус бүргэж, жагсаалтанд оруулжээ. Одоогоор монгол улсад хэдэн өвлөн уламжлагч бүргэгдсэн бэ? Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.5-д “...Түүх, соёлын үнэт дурсгалт дурсгалт зүйлийн болон утга соёлын өвийг ур чадварын өндөр төвшинд өвлөсөн билэг авъяастны жагсаалт, түүнд оруулах, нэмэлт, өөрчлөлтийг мэргэжлийн зөвлөлийн санал болгосноор соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу анх удаа 2003 онд 64 нэр бүхий иргэнийг, 2010 онд 35 нэр бүхий иргэнийг тус тус Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн нийт 100 билиг авъяастны улсын жагсаалтанд оруулж батламж олгожээ.

2.3 Та хэрвээ өөрийгөө соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч гэж бодож байвал хэрхэн хаана бүртгүүлэх вэ?

Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-нд “Түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн болон соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билэг авъяастны жагсаалт, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг мэргэжлийн зөвлөлийн санал болгосноор, Соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” хэмээн заасны дагуу Соёлын биет бус өв, түүний өвлөн уламжлагчийг тогтоох ажлыг Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулсан

Үндэсний зөвлөл зохион байгуулах бөгөөд аймаг, нийслэлд салбар зөвлөл гүйцэтгэдэг байна. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд соёлын онол, түүх, соёлын менежмент маркетинг болон монгол хэлээр илэрхийлэгдэх соёлын биет бус өв, язгуур урлаг, нийгмийн уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам, байгалийн болон сав, шимийн ертөнцийн тухай мэдлэг, заншил, ардын гар урлал, уламжлалт ухааны өвийн чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөллөл багтдаг.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд “Ард түмний билэг авъяас, мэдлэг, туршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болон биет бусаар өвлөгдөн уламжлагдаж ирсэн түүх, угсаатны судлал, ардын билэг, зан үйл, ур хийц, арга барил, дэг сургууль, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий

дараахь оюуны соёлын үнэт зүйлийг соёлын биет бус өвд хамааруулна." гэж заасан:

- 4.1.1. эх хэл, бичиг, түүний хүрээний соёл;
- 4.1.2. аман зохиол;
- 4.1.3. ардын уртын болон богино дуу, тууль, тэдгээрийг дуулах, хайлах арга барил;
- 4.1.4. хөдөлмөр, зан үйлийн холбогдолтой уриа дуудлага;
- 4.1.5. хөөмий, исгэрээ, аман болон тагнай ташилт зэрэг өгүүлэхийн эрхтний шүтэлцээт урлаг, тэдгээрийг илэрхийлэх арга барил;
- 4.1.6. үндэсний хөгжмийн зэмсгийг урлах, хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил;
- 4.1.7. ардын уламжлалт бүжиг, бий, биелгээ;
- 4.1.8. уран нугаралт болон циркийн үзүүлбэрийг илэрхийлэх гоц авъяастны ур чадварын арга барил;
- 4.1.9. ардын гар урлалын дэг сургууль;
- 4.1.10. ардын ёс заншил, зан үйлийн уламжлал;
- 4.1.11. эрдэм ухааны уламжлал;
- 4.1.12. ардын бэлгэдэх ёсны уламжлал.

ЮНЕСКО-гийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгалах тухай конвенц”-д биет бус өвийг тодорхойлохдоо: “Соёлын биет бус өв” гэж хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүс соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зөншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, мэдлэг болон дадал, эдгээртэй холбоо бүхий зэмсэг, эд зүйлс, урлагийн бүтээл, соёлын орон зайг хэлнэ. Биет бус өв нь дараах хэлбэртэй байна.

1. Соёлын биет бус өвийг тээгч хэлийг оролцуулан аман уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэрүүд;
2. Урлагийн тоглолт үзүүлбэрүүд;
3. Заншил, зан үйл, баяр ёслол;
4. Байгаль болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншлууд;
5. Уламжлалт гар урлал;

2.4 Үндэсний бичиг соёлын биет бус өвд орсон байдал

Үеэс үед уламжлагдах соёлын биет бус өвийг хамт олон, бүлэг хүмүүс нь тэдгээрийг хүрээлэн буй орчин, байгаль, түүхийн харилцан шүтэлцээнээс шалтгаалан байнга шинэчилдэг бөгөөд тухайн өв нь тэдгээрт оршин тогтнох болон залгамж чанарын мэдрэмж төрүүлж, соёлын төрөл зүйл, хүний туурвилыг хүндэтгэхэд дэмжлэг үзүүлдэг. Энэхүү конвенцийн зорилгод олон олон улсын хүний эрхийн зөвхөн одоо мөрдөж буй баримт бичиг болон хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн хоорондын харилцан хүндэтгэл, мөн тогтвортой хөгжлийн шаардлагуудад нийцсэн соёлын биет бус өвийг авч үзнэ.

Соёлын биет бус өвд багтсан үндэсний бичгийн тухай

Монгол уран бичлэг бол эртний уламжлалт утга соёл, эрдэм мэдлэг, оюуны боловсрол, хүний дотоод сэтгэлийн торгон мэдрэмжийг монгол бичгийн зурлагаар илэрхийлж үзүүлдэг бийрийн урлаг юм.

Бийрээр бичих нь хүмүүсийн өдөр тутмын амьдралтай холбоотой төдийгүй урлаг гоо сайхны боловсролыг байнга хөгжүүлж байдаг. Дорно дахины улс орнуудад уран бичлэг нь бийр, бэх, цаас, нийлүүрийг ашиглан утга агуулга, үсгийн хэмнэлээр урлагийн бүтээл туурвидаг. Анхны авианы бичиг өрнө зүгт дэлгэрэн Грек, Латин цагаан толгойн үндэс болж, дорно зүгт Арамей, Сири, Согдоор дамжин Уйгур үсэг Монгол бичгийн цагаан толгойн үндэс болжээ. Анх бу болсон цагаасаа өнөөдрийг хүртэл урт удаан хугацаанд хэрэглэгдэж ирсэн монгол үсэг 1000-д жилийн түүхтэй. Монгол уран бичлэг нь нүүдэлчдийн ахуй амьдрал байгаль дэлхийтэй уялдаж зохицсон мэт дээрээсээ доошоо чиглэлтэй нар зөв эргүүлэн бичдэг. Үсгийн бүтэц нь цөөхөн зурлагатай, нэг үсэг нь үгийн эхэнд, үгийн дунд, үгийн адагт гурван янзын дүрсээр тэмдэглэгддэг. Бичих онцлог нь үсгийн зурлагуудаа хооронд нь залгаж үг бүтээж бичдэг. Монгол уран бичлэг нь монгол туургатны утга соёл, оюун сэтгэлгээний бахархал, үндэсний билэг тэмдэг билээ. Уран бичлэгийн үндсэн хэлбэр эртний тиг, хичээнгүй тиг, (албан ёсны бичлэг) гүйлгэн тиг, таталган тиг, эвхмэл тиг, (дугуй эвхмэл, дөрвөлжин эвхмэл) тамганы тиг, хос уянгын төрөл гэх мэт олон янз байдаг.

ГУРАВ ДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ХЭСЭГ

3.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын төлөвлөгөөн дэх үндэсний бичгийн хөтөлбөрийн судалгаа

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, 10.5, Монгол хэлний тухай хуулийн 11.1.2-т заасныг үндэслэн Монгол улсын засгийн газар “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг батлах тухай тогтоол гаргасан. Монгол Улсын Засгийн газраас 1995-2005 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I”, 2008-2015 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II”-ийг тус тус хэрэгжүүлсэн. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I, II” хэрэгжсэнээр ерөнхий боловсролын сургуулийн VI-IX ангид монгол бичиг хичээлийг судалж, иргэний болон боловсролын баримт бичгийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн үйлдэх, ном, сурах бичиг зохиох, хөрвүүлэх, түүх, соёлын бүтээлийг нийтийн хүртээл болгох зэрэг үр дүн бий болсон. Гэвч бүх нийтэд монгол бичгийг сургах, нийтийн хэрэглээний бичиг болгох, хэрэглэх орчин бий болгох зэрэг зорилтууд хангалтгүй байсан. Иймд тус III-р хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ба монгол бичгийн сургалтыг дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсролын салбарт эрчимжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, стандарт дүрэм, журмыг шинэчлэн

батлах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, үүрэг оролцоог нэмэгдүүлэх, уялдуулах нь зүйтэй гэж үзсэн. Тус хөтөлбөрийн

3.2.7. Монгол Улсад сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн сургуульд монгол хэл, бичгийн хичээлийг заавал судлах эрх зүйн зохицуулалтыг бүрэн хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.8. багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн мэргэжлийн ангид монгол бичиг заах аргын хичээлийг тусгайлан оруулах;

3.2.10. 2020-2021 оны хичээлийн жилээс их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд монгол бичгийн хичээлийг заавал судлах; гэсэн заалт оруулж өгснөөр МБТБ байгууллагуудад үндэсний бичгийн хөтөлбөрийн сургалтын агуулгад багтаан судалж байна.

2020-2021 он

БАТЛАВ
ХНХЯ-ны МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА

А. Калмыков

20 20 оны Ү сарын 15 өдөр

СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Мэргэжил: Барилгын цахилгаанчин
Боловсрол: Мэргэжлийн боловсрол
Түвшин: IV

Мэргэжлийн индекс: CF 7411-12
Суралцах хугацаа: 2,5 жил
Элсэгчдийн боловсрол: Суурь

№	Чадмажийн нэгж (судлагдахуун)-ны жагсаалт	Чадмажийн нэгжийн код	Багц цаг	Нийт цаг (5+8+9+10)	Сургалтын цаг										Улирлал				
					Төлөвлөгөө сургалт	Лекц	Семинр, лабораторийн бие даан судалж	Мэдээллийн ж сургалт	Мэдээллийн мэдээлэл	1	2	3	4	5	6	7	8	9	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
А. Бүрэн дунд боловсролын агуулга			59.0	1548	1458	578	882	90			20	21	0	26	27	0	0		
1	Монгол хэл, уран зохиол		5.0	198	198	80	108				2	0		4	4				
2	Үндэсний бичиг		7.0	180	144	72	72	36			2	0		2	2				
3	Математик		5.0	246	216	108	108				2	2		4	4				
4	Нийгмийн ухаан		5.0	108	108	72	36				2	2		2	2				
5	Монголын түүх		2.0	54	54	18	36				2	1		2	2				
6	Газарзүй		3.0	72	72	36	36				1			2	2				
7	Биологи		3.0	72	72	36	36				1			2	2				
8	Физик		3.0	90	90	18	72				1	1		2	2				
9	Хими		3.0	90	90	18	72				1	1		2	2				
10	Гадаад хэл / Англи хэл /		4.5	126	126	36	90				2	2		2	2				
11	Биеийн тамир		4.5	144	126	18	108	18			2	2		2	2				
12	Йргэний ёс зүйн боловсрол		2.0	54	54	18	36				1	1		2	2				
13	Мэдээллийн технологи		2.5	90	72	72	18				2	2		2	2				
14	Эрүүл мэнд		2.5	54	36	36	18				1	1		2	2				
Б. Мэргэжлийн боловсролын агуулга			48.5	2108	958	126	432	90	702	756	19	17	38	12	12	40	38		
Б1. Мэргэжлийн суурь хэсэг			10.5	324	234	36	198	90	0	0	7	2	0	8	0	0	0		
15	Мэргэжлийн англи хэл	BC 100-001-201	1.0	36	36		36												
16	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн швэрдлэгийг хангах ажлаа	BC 100-002-201	1.0	36	36		36				2								
17	Амьдрах ухааны ур чадвар засмал	BC 100-003-201	1.5	54	36		36	18				2							
18	Хувь хүний санхүү, бизнес, аж ахуй заслал	BC 100-004-201	2.0	72	36		36	36					4						
19	Ганцгаас хамгаалах	BC 100-005-201	1.5	54	18		18	36				1							
20	Техникийн зураг зүй	CF 7411-12-01-201	1.5	36	36	18	18				2								
21	Барилгын ажлын үндэс	CF 7411-12-02-201	1.5	36	36	18	18				2								
Б2. Мэргэжлүүлэх хэсэг			38.5	1782	324	90	234	0	702	756	12	15	38	4	12	40	38		
22	Цахилгаан төхмөлийн үндэс	CF 7411-12-03-301	1.5	36	36	18	18				2								
23	Цахилгаан гэрэлтүүлэг угсрах	CF 7411-12-04-301	7.0	324	54	18	36	126	144	10		16							
24	Гадна талбайн гэрэлтүүлэг угсрах	CF 7411-12-05-301	5.0	252	36		36	108	108		8	12							
25	Барилгын цахилгааны самбар угсрах	CF 7411-12-06-301	4.0	198	36		36	72	90		4	10	4						
26	Цахилгаан хөдөлгүүрийг хэлсэнд хөлбөх	CF 7411-12-07-301	9.0	216	54	18	36	54	108					6	12				
27	Гадна цахилгаан хангамжийн угсралт хийх	CF 7411-12-08-401	2.5	126	18		18	54	54					4	6				
28	Аянга хамгаалалт, гавардуулгыг угсрах	CF 7411-12-09-401	3.5	144	36	18	18	54	54					1	6	8			
29	Цахилгааны зэвсэр үйлчилгээ хийх	CF 7411-12-10-401	9.0	432	54	18	36	234	144					1	18	30			
30	Үйлдвэрлэлтэй төмнцөх дадлага		1.0	54	0						54	3							
Сургалтын цаг			162.5	3474	2016	702	1314		702	756	39	38	38	38	38	40	38		
Бие даан судлах цаг			5.0	180				180											
НИЙТ ДҮН			167.5	3654	2340	702	1314	180	702	756	39	38	38	38	38	40	38		
Мэргэжлийн боловсролын агуулгын онол, дадлагын харьцаа								26%		72%	702	684	342	342	702	360	342		

2020-2021 оны
хичээлийн жилд тухайн
Үндэсний бичгийн
цагийг шинээр тавьж
өгсөн байдаг.

ХЯНАСАН:
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
БОЛОВСРУУЛСАН:
ХНХЯ-ны МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН СУРГАЛТЫН
МЕНЕКЕР

Ш.Отгонжаргал

Ш.ОТГОНЖАРГАЛ
Ж.ЦЭЦЭГЖАРГАЛ
Л.ГАНЧИМЭГ

Зураг 1: Сургалтын төлөвлөгөөнд үндэсний бичгийн агуулгыг зааж өгсөн байдал

2023-2024 он



Мэргэжил: Барилгын цахилгаанчин
Боловсрол: Мэргэжлийн боловсрол
Түвшин: IV

Мэргэжлийний индекс: CF 7411-12
Суралцах хугацаа: 3 жил
Элсэгчдийн боловсрол: Суурь

№	Чадварын нэгж (судалгдвалуун)-ийн нэр	Чадварын нэгжийн код	Тасврын сургалт							Тасврын бүс	1 дэх жил			2 дахь жил		3 дахь жил	
			Нийт цаг (5+6+7+10)	Тасврын сургалтын цаг (6+7)	Линц	Сэлэнэр, лабораторийн ажил	Сурууль, дээрх Дэдлага	Бие даан суралцаж Үндэсрэлтийн дэдлага	I		II	III	IV	V	VI		
																4	5
0	1	2	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18
А.Бүрэн дунд боловсролын агуулга			1764	1638	576	1062	0	126	0	29	25	0	0	30	22	0	0
1	Монгол хэл, уран зохиол		198	198	90	108				3	3			4	3		
2	Үндэсний бичиг		198	162	72	90		36		4	2			2	2		
3	Математик		252	252	108	144				4	4			4	4		
4	Нийгэм судлал		108	108	72	36				2	1			2	2		
5	Монголын түүх		54	54	18	36				2	1						
6	Газарзүй		90	90	36	54								4	3		
7	Биолог		90	90	36	54								4	3		
8	Физик		90	90	18	72				2	2			2			
9	Хими		90	90	18	72				2	2			2			
10	Гэдмэд хэл / Англи хэл /		198	198	36	162				4	4			2	2		
11	Биеийн тамир		144	108	18	90		36		2	2			2	1		
12	Иргэний ёс зүйн боловсрол		72	72	18	54				1	1			2	1		
13	Мэдээллийн технологийн		108	90		90		18		2	2				1		
14	Эрүүл мэнд		72	36	36			36		1	1						
Б. Мэргэжлийн боловсролын агуулга			2556	684	126	558	738	0	1134	9	13	27	38	8	16	37	38
Зөвхөн судлах суурь хэсэг			252	252	0	252	0	0	0	2	0	0	0	4	2	8	0
15	Мэргэжлийн өнги хэл	BC100-004-201	36	36		36										2	
16	ХАБЭА-н шаардлагыг хангам ажиллах	BC100-001-201	36	36		36				2							

2023-2024 оны хичээлийн жилд тухайн агуулга нь 198 цаг болж нэмэгдсэн байна.

Зураг 2: Сургалтын төлөвлөгөөнд үндэсний бичгийн агуулгыг зааж өгсөн байдал 2023

Мэргэжлийн боловсролын 3 жилийн /хуучнаар 2,5/ Барилгын цахилгаанчин мэргэжлийг сонгон сургалтын төлөвлөгөөнд “Үндэсний бичиг” хичээлийн агуулгыг 2020-2021 онд 180 цаг байсан нь “Үндэсний бичгийн хөтөлбөр-III” батлагдснаар тухайн хичээлийн цаг нь 198 цаг болж нэмэгдэж орж ирсэн байна. Энэ цагийн сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөөнд цахим үндэсний бичгийг цагийг нэмэгдүүлэн, суралцагчдын ур чадварыг цахим технологитой уялдуулан хөгжүүлж орж байна.

Гуулрал	Монгол бичгийн дүрэм	Эгшгийн эхэн, дунд, адагт ордог хэлбэрээр гийгүүлэгчийг амилуулан зөв бичих. Үе, үг, холбоо үг, өгүүлбэрийг хичээнгүй хуулж бичих. Галигаас үндэсний бичгээр зөв бичих.	3	на,ма, ла-н төрлийн үсгийг таниулах, бичих	2	2	
			4	ба, ра, са,ша -н төрлийн үсгийг таниулах, бичих	2	2	
			5	да, та, жа, за-н төрлийн үсгийг таниулах, бичих	2	2	
			6	ца, ча, га, ха-н төрлийн үсгийг таниулах	2	2	
			7	йа, нг-н төрлийн үсгийг таниулах	2	2	
			8	Бататгал давтлага	2	2	
			9	Гадаад үгэнд ордог үсгүүд	2	2	
	Монгол бичгийн дүрэм	Урт, хос эгшийн бүтэх аргыг судлах, дадлага ажил хийх	10	Урт ба хос эгшиг	2	1	1
			11	Нэрийн хувилал	2	1	1
			12	Бататгал давтлага	2	2	
			13	Дэвсгэрлэх ба үл дэвсгэрлэх ёс	2	1	1
			14	Үйлийн хувилал	2		2
			15	Бататгал давтлага	2	2	
	Дуудлага бичлэг тохирдог үгийг уншиж бичих, нүдлэн тогтоох	дэвсгэр үсгийн тухай ойлголтыг баталгааж үйл үгийг үйлийн нөхцлүүдээр зөв хувилган бичих					

Зураг 3:Багшийн жилийн хичээлийн төлөвлөгөөнд үндэсний онцлог тусгасан байдал

Уулрал	Нэгж хичээлийн сэдэв	Суралцахуйн зорилт		Д/д	Ээлжит хичээл	Цаг	Цаг	
		Танхим	Цахим				Танхим	Цахим
Уулрал	Монгол ёс заншил	Монгол ёс заншил сэдэвт эхээс уншиж бичих		1	Мэндлэх ёсон эхийг уншиж улс үндэстнүүдийн мэндлэх заншил нь ямар ямар байдаг	2	2	
				2	Мэндлэх ёсон эхийг бичиж дасгал ажиллах	2	2	
				3	Монгол хүн бэлгээрээ эхийг уншиж ойлгох	2	2	
				4	Монгол хүн бэлгээрээ эхийг бичиж, дасгал ажиллах	2	2	
				5	Мэндийн үгс эхийг уншиж, бичих, дасгал ажиллах	2	2	
				6	Малгайгаа авахын учир эхийг уншиж, дасгал ажиллах	2	2	
				7	Хүндлэн зочлох ёсон эхийг уншиж ойлгох дасгал ажиллах	2	2	
				8	Уул овоо шүтэх эхийг уншиж ойлгох, дасгал ажиллах	2	2	

Зураг 4:Багшийн жилийн хичээлийн төлөвлөгөөнд үндэсний онцлог тусгасан байдал 2

3.2 Суралцагчдад үндэсний бичгээр дамжуулан монгол өв соёлыг өвлүүлэн тээн хөгжүүлж буй боломжууд

Судалгааны объектоор тус сургуулийн Мэргэжлийн боловсролын 3 жилийн ангиудыг сонгон хийлээ. 2020-2021 оны хичээлийн жилийн хөтөлбөр шинэчлэгдэн орж ирснээр сургуулийн 1,2-р курсын үндэсний бичгийг танхим болон дугуйланд хамрагдсан байдлаар авч үзвэл

Мэргэжлийн боловсролын 3 жилийн ангиуд үндэсний бичгийг танхимаар судалж буй суралцагчид

№	Анги	2020-2021	2021-2022	2022-2023
1	1-р курс	91	111	124
2	2-р курс	109	90	109




График 2: Мэргэжлийн боловсролын 3 жилийн ангиуд үндэсний бичгийг танхимаар судалж буй суралцагчид

“Уран бийр” дугуйлангийн суралцагчдын тоо

Хүснэгт 1: “Уран бийр” дугуйлангийн суралцагчдын тоо:

№		2020-2021	2021-2022	2022-2023
1	Багш	2	3	5
2	Суралцагч	6	12	18




График 3: “Уран бийр” дугуйлангийн суралцагчдын тоо

Үндэсний бичгийг сурч өөрийгөө хөгжүүлж байгаа суралцагч болон багш, ажилчдын дунд зохион байгуулдаг уралдаан болон бүтээлийн үзэсгэлэнгийн тоо

Хүснэгт 2: Багш суралцагчдын бүтээлийн тоо

№	Бүтээлийн төрөл	Хамрах хүрээ	Бүтээлийн тоо
1	Хичээнгүй бичиг	Багш, оюутан	212
2	Эвхмэл бичиг	Багш, оюутан	180
3	Цахим бичвэр	Багш	300
4	Бийрийн бичвэр	Оюутан	200




График 4: Багш суралцагчдын бүтээлийн тоо

Дээрх судалгаанаас харахад үндэсний бичгийг сонирхон суралцагч буй суралцагч багш ажилчдын тоо жил бүр өссөн үзүүлэлтэй байгаа бөгөөд тэдний хийсэн бүтээлийн тоон үзүүлэлт маш өндөр хувьтай байна. Энэ нь суралцагчид, цаашлаад багш ажилчдын үндэсний бичгийн чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаа, өөрсдийн оролцоо идэвх чармайлтын үр дүн юм. Мөн үндэсний бичгийг хөгжүүлэх, өв соёл уламжлалыг тасралтгүй авч явж байгаа багшийн идэвх зүтгэлийн илрэл юм.

3.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын онцлогтой уялдуулсан үндэсний бичгийн бүтээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн судалгаа

Манай салбар нь өөрсдийн хийсэн ажил үйлчилгээ, үйлдвэрлэл, оюуны өмч, бүтээлээр өөрийн үйл ажиллагааны орлого олох хамгийн том боломжтой төдийгүй үүнийг салбарын хуулинд тодорхой заасан байдаг. Энэ утгаараа үндэсний бичгээр хийсэн бүтээл хамтарсан байгууллага, санхүүгийн боломжыг судалж үзэхэд

Хамтарч ажилласан байгууллага хувь хүний тоо

Хүснэгт 3: Хамтарч ажилласан байгууллага

№		2020-2021 он	2021-2022 он	2022-2023 он
1	Хамтарсан байгууллагын тоо	3	8	15
2	Хувь хүн	12	28	47




График 5: Хамтарч ажилласан байгууллагын харьцаа

Говьсүмбэр аймаг дахь Политехник
2022-2023 онд захиалга өгсөн байгууллагын жагсаалт

Хүснэгт 4:Хамтран ажилладаг байгууллагуудын захиалгууд

№	Байгууллагын нэр	Захиалгын нэр	Үнэ
1	Шивээговь сумын ИТХ	Талархал	240,000
2	Шивээ-Овоо ХК	Даавууны бичээс	600,000
3	Шивээговь сум ХБИ	Өргөмжлөл	Хандив
4	ГСА Эмнэлэг	Өргөмжлөл	120,000
5	ГСА Шагайн харваа холбооны бүсийн уралдаан	Өргөмжлөл	120,000
6	Төмөр зам 3-р анги спортын тэмцээн	Өргөмжлөл	120,000
7	Баян тал ИТХ	Өргөмжлөл	310,000
8	ГСА ПТК МБС-ын спортын улсын аваргын өргөмжлөл	Өргөмжлөл	840,000
9	ГСА Ойн анги	Хөшигний бичвэр	200,000
10	МБС-ын спортын улсын аваргын өргөмжлөл	Талархал	720,000
11	Байгууллагын аварга өргөмжлөл ПТК	Өргөмжлөл	200,000
12	ГСА ЗДТГ Тогоочдын аймгийн аварга	Өргөмжлөл	240,000
13	Хувь хүн	Хүний нэр	350,000
14	Хувь хүн Дурсгалын зүйл	Одонтой ээж, Үлэмжийн чанар	245,000
15	ГСА БСУГ	Өргөмжлөл	120,000
16	Нийт		4,225,000

Дээрх судалгааг дүгнэхэд 2021, 2022 онуудад зөвхөн суралцагчдын бүтээлээр дугуйлан болон үзэсгэлэнгийн үйл ажиллагаа явагдсан. Нөгөөтэйгүүр цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор байгууллагууд дахь үйл ажиллагаанууд хумигдмал байдалтай төдийлөн олон нийтийг хамарсан ажлууд цөөн явагдсантай холбоотой. 2023 онд хамтран ажилласан байгууллагууд нь хувь хүн, албан байгууллага, цаашлаад аймаг орон нутгийн засаг захиргаа, түншлэлийн холбоотой байгууллагууд хамтран ажилласан байна. Энэ тоон үзүүлэлт ч цаашид улам ихсэх хандлагатай байгаа юм.

3.4 Үндэсний бичгийн төрлүүдийг дэвшилтэт технологийг ашиглан фонд зохиох, аппликейшнаар дамжуулан орлогын эх үүсвэр бий болгомжийн судалгаа

Үндэсний бичгийн сургалтын хөтөлбөрөөр олон төрөлт хэлбэрүүдийг судалдаг. Энэ төрлүүдээр үзэсгэлэн бүтээлийн уралдаан, бүтээл болгон борлуулахад тухайн хүнээс ихээхэн хүчин чармайлт, ур чадвар, тэвчээр шаардагддаг. Мөн тухайн бүтээлийг хийхэд шаардагдах хэмжээний хөнгөвчилж, цаашлаад бүтээлээр

орлого олж, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд цахим технологийн хөгжил зайлшгүй хэрэгцээтэй байгаа юм. Иймд үндэсний бичгийн төрлийн нэг болох бийрэн бичгийн хэвээр үсгийн фонт зохиож, цаашлаад олон төрлийн хэвийг хөгжүүлж, аппликейшн болгон хөгжүүлэх боломжийг судалж байна. Монгол бичгийн багш А.Шинэбаярын бийрэн бичгийн тигийг ашиглан Mb biig нэртэй бичвэрийн фонт зохион бүтээсэн. Уг фонтоор бийрэн бичгийн хэв бүхий бичвэрийг бичих боломжтой. Фонтоо нийтэд нээлттэй эрхтэйгээр тавихгүйгээр бүртгэлийн программ хослуулан төлбөртэйгээр ашиглуулах ажлыг эхлүүлээд байна.

Судалгааны нэгдсэн дүгнэлт

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын онцлог үйл ажиллагаа нь суралцагчдын бүтээлч үйл ажиллагаа, ур чадварыг үргэлж дэмжсэн боломжуудыг бий болгож байдаг нь дээрх судалгааны байнгын өссөн үзүүлэлттэй байгаагаар илэрхийлэгдэж байна.

Үндэсний бичгийн боломжуудыг харуулсан судалгаа нь зөвхөн мэргэжлийн боловсролын ангиудад хийгдсэн байгаа нь цаашид энэхүү тоон үзүүлэлтүүд үүнээс илүү өндөр гарах бүрэн боломж байна. Мөн нийгмийн түншлэл, хамтран ажиллагч байгууллага, орон нутгийн засаг захиргаа нь МБС-ыг дэмжиж оролцдог, цаашлаад тухайн байгууллагууд тэдгээр байгууллагуудын дэмжлэгээр өөрсдийн бүтээлч үйл ажиллагаа, үйлдвэрлэлийг илүү хөгжүүлэх боломжууд байнга байдаг.

Иймд энэ боломжуудыг ашиглан үндэсний бичгийн бүтээл хийх цахим хөгжүүлэлт, технолоший дэвшлийг ашиглан бүтээмжийг илүү өндөр болгож, цаашлаад оюуны өмчийн бүтээлийг гарган өөрийн үйл ажиллагааны боломжийг нэмэгдүүлэх, хөрөнгийн эх үүсвэр бий болгох бүрэн боломж байна.

Ном зүй

- <https://sdg.1212.mn/> Үндэсний статистикийн хороо Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- <https://www.montsame.mn/mn/read/90502> Монцаме Зайн сургалт нь зардал хэмнэхээсээ илүү чанартай мэргэжилтэн бэлдэхэд чухал ач холбогдолтой нийтлэл
- <https://worldscholarshipforum.com/mn/what-is-distance-learning/> Алсын зайн сургалт
- Ж.Төгсөө ,Т.Оюун-Эрдэнэ, С.Сайнзаяа - Танхим болон цахим хосолсон сургалтын онол, арга зүйн зарим асуудал-Улаанбаатар 2020 он
- <https://www.mastersportal.com/>
- [МастерПортал](#)
- [Шилдэг их сургуулиуд](#)
- [Википедиа](#)
- [Viewsonic](#)
- [Техсмит](#)

Хавсралт





Сургалтын арга зүйч Ж.Норжмаа, МХБУЗ-ын багш Д.Дашдулам, Математикийн багш Бүдханд, Жмч Алтанцэцэг нар эвхмэл бичгээр бүтээл хийж үзэсгэлэнд оролцов.





Сургалтын арга зүйч Ж.Норжмаа



Багш М.Сандагсүрэн

Дугуйлан маань 10,11,12 сард эвхмэл бичиг бичиж бүтээл хийж үзэсгэлэн гаргаж ажилласан бөгөөд 1,2,3 сараас Том бийрийн бичвэрээр хичээллэж эхний хүүхдүүд сургалтаа дүүргэж бүтээлээ хийсээр байна.



Авто засвар 1а Эрдэнэбаатар

Аймгийн хэлний бодлогын зөвлөлөөс зохион байгуулсан Бийрийн бичгийн уралдаанд оролцов. Багш Д.Дашдулам болон миний бие, Эрдэнэбаатар 10-12 ар ангийн төрөлд оролцов.

Амжилт: Багшийн төрөлд 3-р байр эзэлсэн.



2022-2023 оны хичээлийн жил ЭВХМЭЛ бичгээр 9 суралцагч бичиж сурсан бөгөөд бийрээр 12 суралцагч бичиж суралцлаа.

2 удаагийн үзэсгэлэнд оролцов.





